

ИХ ӨГӨГДӨЛ, ХИЙМЭЛ ОЮУНЫ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ

Нэг. Алсын хараа

1.1.Монгол Улс төв Азийн дижитал эдийн засгийн “Баянбүрд”-ийг цогцлооно.

Хоёр. Эрхэм зорилго

2.1.Үндэсний давуу тал, ялгарлыг түшиглэн нийгэм, эдийн засаг, байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн их өгөгдөл, хиймэл оюуны экосистемийг хөгжүүлж, Ази тивдээ тэргүүлэгч 10 улсын нэг болно.

Гурав. Стратегийн зорилт

3.1.Стратегийн хүрээнд дараах зорилтуудад хүрнэ. Үүнд:

3.1.1.Үндэсний их өгөгдлийг зах зээлийн зарчимд суурилан эдийн засгийн эргэлтэд оруулна.

3.1.2.Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан ёс зүйтэй, хариуцлагатай хиймэл оюуны тогтолцоог бүрдүүлнэ.

3.1.3.Хувийн хэвшлийн хөгжүүлсэн хиймэл оюуныг ашиглах замаар нийгэм, эдийн засгийн тэргүүлэх салбаруудын бүтээмжийг нэмэгдүүлнэ.

3.1.4.Хиймэл оюуны дэд бүтцийн зах зээлд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах замаар дижитал эдийн засгийн өсөлтийг хурдасгана.

Дөрөв. Стратегийн баримтлах зарчим, хугацаа

4.1.Стратегийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

4.1.1.хүний эрх, ёс зүйн зарчим, аюулгүй байдлыг хангасан, хүн төвт хөгжилд чиглэсэн байх;

4.1.2.хэнийг ч орхигдуулахгүй байх;

4.1.3.харилцан уялдаатай, нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх;

4.1.4.нөөц бололцоонд үндэслэсэн байх;

4.1.5.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;

4.1.6.төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;

4.1.7.төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан байх.

4.2.Стратегийг дараах үе шаттай хэрэгжүүлнэ:

4.2.1.Нэгдүгээр үе шат буюу 2025-2027 он;

4.2.2.Хоёрдугаар үе шат буюу 2028-2030 он.

Тав. Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх арга зам

5.1. Үндэсний их өгөгдлийг зах зээлийн зарчимд суурилан эдийн засгийн эргэлтэд оруулах зорилтыг дараах арга замаар хэрэгжүүлнэ:

5.1.1.Дэвшилтэт технологийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд чиглэсэн өгөгдлийн анхдагч хуулийн төслийг боловсруулан, батлуулж, эрх зүйн таатай орчныг бий болгоно.

5.1.2.Төрийн байгууллагын зүгээс өөрийн өгөгдлийн багцыг их өгөгдлийн санд нийлүүлэх чиг үүргийг одоогийн нөөц, бүтэц, зохион байгуулалт дээр тулгуурлан удирдлага, зохион байгуулалтад шилжүүлнэ.

5.1.3.Их өгөгдлийг эргэлтэд оруулах хатуу, зөөлөн дэд бүтцийг нэгдсэн бодлогоор зохион байгуулна.

5.1.4.Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд түшиглэн зах зээлийн зарчимд суурилан тэргүүн ээлжинд төрийн өгөгдлийн санг үе шаттайгаар үүсгэж, Үндэсний их өгөгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулна.

5.2.Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан ёс зүйтэй, хариуцлагатай хиймэл оюуны тогтолцоог бүрдүүлэх зорилтыг дараах арга замаар хэрэгжүүлнэ:

5.2.1.Хүний эрх, ёс зүйн зарчим, аюулгүй байдлыг эрхэмлэсэн Үндэсний хиймэл оюуныг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бий болгоно.

5.2.2.Төрийн байгууллагын зүгээс хиймэл оюуныг хөгжүүлэх, хэрэглэх чиг үүргийг одоогийн нөөц, бүтэц, зохион байгуулалт дээр тулгуурлан удирдлага, зохион байгуулалтад шилжүүлнэ.

5.2.3.Олон улсад нийцсэн сургалтын хөтөлбөрийг бүх шатны албан боловсролын системд нэвтрүүлнэ.

5.2.4.Хүний эрх, ёс зүйн зарчимд нийцсэн, хиймэл оюуны талаарх мэдлэг, ойлголтыг олон нийтэд таниулж, соён гэгээрүүлнэ.

5.3.Хувийн хэвшлийн хөгжүүлсэн хиймэл оюуныг ашиглах замаар нийгэм, эдийн засгийн тэргүүлэх салбаруудын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилтыг дараах арга замаар хэрэгжүүлнэ:

5.3.1.Үндэсний өгөгдлийн багц (dataset)-ын давуу тал, ялгаралд тулгуурлан уул уурхай, эрчим хүч, банк санхүү, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, батлан хамгаалах зэрэг тэргүүлэх салбарт хиймэл оюуны загвар хөгжүүлэлтийн (R&D) төслүүдийг хэрэгжүүлэх замаар бүтээмжийг нэмэгдүүлнэ.

5.3.2.Хиймэл оюуны бүтээгдэхүүн, үйлчилгээг экспортлоход зориулж дотоодын хөгжүүлэгчдэд төрөөс үндэсний их өгөгдлийн сангийн үнэ цэн бүхий өгөгдлийн багц болон өндөр хүчин чадалтай тооцоолох төв дээр ажиллуулах, тарифын болон тарифын бус саад тотгоруудыг багасгана.

5.4. Хиймэл оюуны дэд бүтцийн зах зээлд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах замаар дижитал эдийн засгийн өсөлтийг хурдасгах зорилтыг дараах арга замаар хэрэгжүүлнэ:

5.4.1.Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар хиймэл оюуны олон улсын дата төв байгуулахад хууль, эрх зүйн нэн таатай орчныг (ААНОАТ, Гаалийн татвар, бусад төлбөр хураамжуудыг хөнгөлөх) орчныг бүрдүүлнэ.

5.4.2.Хямд өртөг бүхий эрчим хүчний эх үүсвэр, нөөцүүдийг түшиглэн хиймэл оюуны олон улсын дата төвүүдэд зориулсан эдийн засгийн чөлөөт бүсүүдийг байгуулна.

5.4.3.Хиймэл оюуны олон улсын дата төвүүдийн хил дамнасан өгөгдөл солилцох боломжийг бүрдүүлж, интернэтийн шинэ гарцыг нээнэ.

Зургаа.Стратегийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө оруулалт

6.1.Үндэсний стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газар, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангана.

6.2.Их өгөгдөл, хиймэл оюуныг хөгжүүлэх үүрэг бүхий байгууллагууд энэхүү стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлнэ.

6.3.Стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсөв, хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл, буцалтгүй тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт байна.

6.4.Стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлох, байгууллагын хүний нөөцийг чадавхжуулахтай холбоотой зардлыг тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч нар хариуцна.

Долоо. Стратегийн зорилтын шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин

7.1.Стратегийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот он	Зорилтот түвшин	Тайлбар
Зорилт 1. Үндэсний их өгөгдлийг зах зээлийн зарчимд суурилан эдийн засгийн эргэлтэд оруулна.	Өгөгдлийн харилцан ажиллагаатай байдлын үзүүлэлт	Оноо	2030	4.5/5	НҮБХХ,ЦХИХХЯ, Монгол Улсын хиймэл оюуны бэлэн байдлын үнэлгээний тайлан 2025 он (2.2 дэд үзүүлэлт) одоо “Ялгарах үе шат”

					3.1 оноотой үнэлэгдсэн.
Зорилт 2. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурлан ёс зүйтэй, хариуцлагатай хиймэл оюуны тогтолцоог бүрдүүлнэ.	Хиймэл оюуны бэлэн байдлын индексийн эрэмбэ	Улс орнуудын эрэмбэ	2030	50 (Азид 10)	Оксфорд инсайтс (oxford insights ai readiness index 2025) одоо 98-т эрэмбэлэгдэж байгаа
	Хиймэл оюуны ёс зүйн бэлэн байдлын үзүүлэлт	Оноо	2030	4/5	НҮБХХ,ЦХИХХЯ, Монгол Улсын хиймэл оюуны бэлэн байдлын үнэлгээний тайлан 2025 он (тулгуур чиглэл 3) одоо “Тогтолцоо бүрэлдэх үе шат” 2.4 оноотой үнэлэгдсэн.
Зорилт 3. Хувийн хэвшлийн хөгжүүлсэн хиймэл оюуныг ашиглах замаар нийгэм, эдийн засгийн тэргүүлэх салбаруудын бүтээмжийг нэмэгдүүлнэ.	Экспортолсон хиймэл оюуны загвар	Тоо	2030	10	Үндэсний давуу тал, ялгаатай байдалд тулгуурлан хөгжүүлсэн хиймэл оюуны загварыг экспортолсон тоо
	Дижитал эдийн засгийн өсөлт	Хувь	2030	Тооцсон суурь түвшинг 1 дахин өсгөх	Үндэсний тооцооны системд дижитал эдийн засгийн үзүүлэлт тооцох аргачлалыг нэвтрүүлж тооцно.
Зорилт 4. Хиймэл оюуны дэд бүтцийн зах зээлд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах замаар дижитал эдийн засгийн өсөлтийг хурдасгана.	Олон улсын дата төв	Тоо	2030	1	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдсан олон улсын стандарт бүхий дата төв байгуулна.
	Шинээр нэмэгдүүлсэн интернэт гарц	Тоо	2030	1	Интернэт гарцын гуравдагч эх үүсвэрийг бий болгоно.

Найм. Стратегийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

8.1.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэхүү стратегийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үе шат дуусах бүрд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулна.